

Батлав. Говьсүмбэр аймгийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга.

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“БАС ГОВЬ” ХХК-ийн захирал Б.ЦЭВЭЭН

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ, СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ
“БАС ГОВЬ” ХХК - ЫН
(ТӨСЛИЙН БАЙРШИЛ, НЭР)**

**2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 4279344/

Хянасан: Говьсүмбэр аймгийн байгаль орчны асуудал хариуцсан газрын
мэргэжилтэн _____

Биелэлтийг тайлагнасан:

“БАС ГОВЬ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.ЦЭВЭЭН /

“БАС ГОВЬ” ХХК-ийн ХАБЭА-н ажилтан Д.ЖАРГАЛМАА /



2024 он

1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаар хөрсөн бүрхэвч, ургамал болон тухайн орчинд амьдарч, ажиллаж буй хүмүүст гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөнүүдийг багасгах, бууруулах арга хэмжээг тогтоох
- Дээрхи арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6-д заасны дагуу ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл гаргуулсан. 30.1.4.ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах гэсний дагуу тоолууржуулж баталгаажуулж ажиллаж байна. Цаашид Усны тухай хуулинд заасан аж ахуйн нэгж байгууллага хэрэгжүүлэх бүх заалтуудыг дагаж мөрдөж ажиллана.

 СТАНДАРТ,
ХЭМЖИЛЭЭНИЙ
ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ ЭУ141686.....

.....-д
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа LXSG загварын 10 м3/ц м³/ц
хэмжих хязгаартай, 32 мм-ийн голчтой № 202301857 -ын
халуун, хүйтэн усны тоолуурыг № 018 лацаар битүүмжилж
(доогуур зургах)

..... 2026 оны 08 -р сарын 09 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 00001 м³

Лабораторийн тэмдэг

2024 оны 08 -р сарын 09 -ны өдөр

Улсын шалгагчийн
гарын үсэг, тэмдэг

 Усны тоолуур суурилуулах үеийн акт

№8

2024 оны 11-р сарын 11

Говьсүмбэр

БАС ГОВЬ ГРУПП ХХК-танд

ЛХСБ- хэсгийн 052м-ийн голчтой хүйтэн усны № 141686 дугаартай тоолуурыг №648893 дүгнэлт, зөвшөөрөл гаргаж буй шугам хоолой дахь усны зарцуулалт хэмжээг үндэс хийгдэн ус ба халуун усны тоолуур суурилуулахад табигдах шаардлага MNS ISO 4064-2:2013 стандартын дагуу суурилуулсан болно. Тоолуурын хүчинтэй хугацаа 2026.08.09 өдөрчлөх хойш 2 жилийн хугацаанд ажиллана. Суурилуулж үеийн заалт 00001


Акт үйлдсэн:

УХАТ Ижтөхөгч: /Б. Нарангзуул/

Тоолуур суурилуулсан:

СЭ-ны захирал: /У.Бат-Эрдэнэ/

Шалгалт хийсэн: /...../



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Бөгд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: БАС ГОВЬ ЭНЕРЖИ ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО

Ус, 1

ЗАХИАЛГА №: 2024/1860

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2024.10.29

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2024.11.15

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 1

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дэжид хамаарна.
Дэжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер:



Д.Пүрэвжаргал


Хамтран амжилласан танд талархлаа.

ЗАХИАЛГА №: 2024/1860

ДЭЭЖИЙН ДУГААР: I

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-18547

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	7.63	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали (K ⁺)	мг/л	3.29	-	MNS 5465:2005
3	Натри (Na ⁺)	мг/л	219.2	200.0	
4	Кальци (Ca ²⁺)	мг/л	50.20	100.0	MNS ISO 2572:1999
5	Магни (Mg ²⁺)	мг/л	31.53	30.00	
6	Аммоии, (NH ₄ ⁺)	мг/л	<0.10	1.50	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид, (Cl)	мг/л	199.1	350.0	MNS ISO 9297:2005
8	Сульфат (SO ₄ ²⁻)	мг/л	163.8	500.0	MNS 3652.4:1984
9	Нитрит (NO ₂ ⁻)	мг/л	<0.05	1.00	MNS ISO 11885:2011
10	Нитрат, (NO ₃ ⁻)	мг/л	<0.01	50.00	MNS 4431:2005
11	Карбонат (CO ₃ ²⁻)	мг/л	6.00	-	MNS ISO 7890-3:2001
12	Гидрокарбонат (HCO ₃ ²⁻)	мг/л	335.6	-	MNS ISO 9963-1:2005
13	Нийт хатуулаг	мг-экв/л	5.10	7.00	MNS 4423:1997
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	862.0	1000	
15	Цахиурын хүчил, H ₂ SiO ₃	мг/л	11.81	-	MNS ISO 4889:1999
16	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	1.44	-	
17	Фосфат, PO ₄ ³⁻	мг/л	<0.05	3.5	MNS ISO 6878:2001
18	Фтор, F	мг/л	0.15	0.7-1.5	MNS ISO 10359-1:2002
19	Хүхэрстусөрөгч, H ₂ S	мг/л	<0.10	0.1	
20	Үлдэгдэл хлор, Cl _{res}	мг/л	<0.10	0.2-0.3	MNS ISO 7393-1:2001
21	Булингар	NTU	<10.0	1.5	
22	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1	MNS (ISO) 11885:2011
23	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.50	
24	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	MNS (ISO) 11885:2011
25	Бор, B	мг/л	0.43	2.40	
26	Барн, Ba	мг/л	0.02	0.70	MNS (ISO) 11885:2011
27	Берелли, Be	мг/л	<0.001	0.0002	
28	Кадми, Cd	мг/л	<0.001	0.003	MNS (ISO) 11885:2011
29	Кобальт, Co	мг/л	0.001	-	
30	Хром, Cr	мг/л	<0.005	0.05	MNS (ISO) 11885:2011
31	Эс, Cu	мг/л	<0.02	2.0	
32	Төмөр, Fe	мг/л	0.08	0.3	MNS (ISO) 11885:2011
33	Марганец, Mn	мг/л	0.09	0.1	
34	Молибден, Mo	мг/л	<0.005	0.07	MNS (ISO) 11885:2011
35	Никель, Ni	мг/л	<0.005	0.02	
36	Хартуулга, Pb	мг/л	<0.01	0.01	MNS (ISO) 11885:2011
37	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.02	
38	Селен, Se	мг/л	<0.01	0.04	MNS (ISO) 11885:2011
39	Стронци, Sr	мг/л	1.15	2.00	
40	Уран, U	мг/л	<0.03	0.03	MNS (ISO) 11885:2011
41	Цайр, Zn	мг/л	0.04	5.0	
42	Цианид, CN _{free}	мг/л	<0.002	0.01	MNS ISO 6703(II):2005
43	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.001	EPA Method 7473





ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: МБ 2024/453

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,
ТОО:

Ус, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: БАС ГОВЬ ГРУПП ХХК

ДЭЭЖИЙН ДУГААР: Ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-1638

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, мл: 500

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 0900:2018	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн сөрөнхий тоо	MNS ISO 6222:1998	1 мл-д	100	23
2	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
3	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч юм	MNS ISO 19250:2017	25 мл-д	илрэхгүй	илрээгүй
5	Clostridium perfringens	MNS ISO 6461-2:1998	100 мл-д	илрэхгүй	илрээгүй
Чанарын менежер			Д.Пүрэвжаргал		

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжид хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг тусгай лаборатори хариуцахгүй болно.

ДЭЭЖИЛСЭН ОГНОО: 2024.10.29

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2024.10.30


ШИНЖИЛГЭЭ ДУУССАН ОГНОО: 2024.11.11

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй


ХУУДАСНЫ ТОО: 1


Хамтран ажилласан таньд талархлаа.

- Төслийн талбайн гадна ашиглаж байсан зориулалтын бус нүхэн жорлонг булж, септик системийг ашиглаж Монгол улсын саарал усыг хөрсөнд шингээх норм /MNS EN 12566:2015/ -р баталгаажсан, Жилийн 4 улиралд ашиглах, үнэр гарахгүй, газар төлөвлөлтөнд өөрчлөлт оруулахгүйгаар бохирын асуудлыг шаардлага хангасан стандартын дагуу 10 сая төгрөгийн төсөвтэйгээр хийж гүйцэтгэн ашиглаж байна.




- Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устахаас сэргийлж барилга байгууламж баригдах үеийн хог хаягдал гарах бүрт нэг цэгт төвлөрүүлж хогийн цэгрүү зөөвөрлөж хаядаг болно.
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Төслийн талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор эдэлбэр газрын 9.000 мкв талбайг хатуу хучилттай болгож нийт 450,000,000 төгрөгийг зарцуулж ажиллажээ.





3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний нэг хэсэг болох талбайг цөлжилтөөс сэргийлэх зорилгоор төслийн талбайд 1000 ш модыг тарьсан. Мөн өмнөх жилд тарьж ургуулсан моднуудыг тогтмол арчилж усалдаг болно.






4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн (гүйцэтгэлийн шатанд) барилга байгууламжийг барих, газар шорооны ажлын үед газрын хөрсөн доороос түүхийн дурсгалт зүйл, соёлын өв одоохондоо илрээгүй бөгөөд илэрсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож энэ тухай уг асуудлыг хариуцсан байгууллага холбогдох газарт нь нэн даруй мэдэгдэх.

5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

- Төслийн талбайн ажилчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа тогтмол өгч, ажлын хувцас нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангаж, мөн ХАБЭА-н заавар зааварчилгаа, байгууллагын дотоод дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна.
- Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллаж байна.



6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

- Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3.-т заасны дагуу шаардлага хангасан энгийн хог хаягдлыг 4-5 төрөлд ангилан ялгах зориулалттай хогийн савийг 1 сая төгрөгийн төсөвтэйгээр хийж байршуулсан. Мөн ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах анхан шатны мэдлэгийг олгож ажиллаж байна.



- Дахин боловсруулах бололмжгүй хог хаягдлыг цуглуулж аймгийн Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан сар бүр тогтмол ачуулж, гэрээний дагуу гарсан төлбөрийг цаг тухай бүрт тогтмол төлж барагдуулж байна.
- Манай компани нь хяналтын бүсийн газрыг өргөтгөж, хуучин ашиглаж байсан 2 төмөр замыг тус бүр 25 вагон ачих хэмжээнд уртасгаж барьсан мөн шинээр 50 вагон ачих хүчин чадалтай төмөр зам барьсан. Ингэхдээ хяналтын бүсийн газрын туйр хог хаягдал, цэвэрлэж, талбайн бүх хэсгийн газрыг автогридер болон индүүгээр тэгшилсэн.

7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо, Ундны усны бүрэн шинжилгээг Улаанбаатар хот дахь итгэмжлэгдсэн Ханлаб шинжилгээний лабораторид өгч нийт 200,000 төгрөгийн төсөвтэйгээр хийлгэсэн.

8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

- Жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийж батлуулан тухайн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гаалийн хяналтын бүсийн эрхлэгч, үйл ажиллагааг хариуцсан ажилтан нар хамтран шат дараатайгаар ажлуудыг хийж гүйцэтгэдэг.
- Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд мод тарих ажлыг 2024 оны 10 дугаар сарын 7, 8-9-ний өдрүүдэд компанийн нийт ажилчид хийж гүйцэтгэсэн.
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээн дэх ажлуудыг 2024 оны 2-р улирлаас эхлэн шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлын тухай хуулинд заасан аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүргийн дагуу ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талууд тайлагнах төлөвлөгөөний биелэлт

- Хяналтын бүсийн ажилчид, хяналтын бүсийн үйлчлүүлэгч нар, оршин суугч нарыг байлцуулан компанийн БОМТ-г танилцуулан түүнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнах зөвлөгөөнийг 2024 оны 12 дугаар сарын аль нэг боломжит өдөр хийхээр төлөвлөсөн байгаа.